



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 17 өдөр

Дугаар 8/481

Мөрөн сум

Дэд ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит XXIII хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Намрын ногоон өдөр 2024”, үзэсгэлэн худалдааны шилдэг шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Иргэд, олон нийтэд сурталчлах, төсөлд оролцогч талуудын уялдаа холбоог сайжруулж, төслийн үр дүнг дээшлүүлэх, удирдамжийн дагуу зохион байгуулж, ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Засаг даргын Тамгын гарзын дарга (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.

3. Үзэсгэлэн худалдаанд орон нутгийн бизнес эрхлэгч, жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нарыг дэмжин, бэлтгэл зохион байгуулалтыг ханган оролцуулахыг сумдын Засаг дарга, холбогдох агентлаг, байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР

Аймгийн Засаг даргын орлогч даргын
2024 оны 09 дүгээр сарын 17 өдрийн
2/48 дүгээр захирамжийн хавсралт

“НАМРЫН НОГООН ӨДӨР 2024”, ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААНД ОРОЛЦОГЧДЫН
ШИЛДЭГ ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Э.Улам-Өсөх -(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Х.Буянтогтох-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого
төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

М.Даваадулам (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Д.Золжаргал--(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн
хэлтсийн Шударга өрсөлдөөн, хууль зүйн салбар дундын
асуудал хариуцсан ажилтан)

Ч.Одбаяр -(Эрүүл мэндийн газрын хүүхдийн хоол тэжээл хариуцсан
хяналтын улсын байцаагч)

А.Даваадорж -(Байгаль орчны газрын Байгаль орчны хяналтын улсын
байцаагч)

Ч.Өлзий-Орших -(ХХААГ-ын Хүнсний үйлдвэрлэлийн хяналтын улсын
байцаагч)

Б.Отгонтуяа-(Стандарт хэмжил зүйн хэлтсийн бүтээгдэхүүн
баталгаажуулалтын)

Нарийн бичгийн дарга:

Б.Цолмонбаяр-(ХХААГ-ын үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний албаны
дарга)